

Аудит хийгдсэн байгууллага:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниуд

Огноо: 2022 оны 11 сар


ДОТООД АУДИТЫН НЭГЖ: Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хийх үүрэг бүхий ажлын хэсэг

**- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -**

Аудитын нэр: “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх

Жил: Хамрах хугацаа 2022 оны 1-9 дүгээр сар

Огноо 2022 оны 11 дүгээр сар



АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хийх үүрэг бүхий ажлын хэсэг,

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниуд

АУДИТЫН ТӨРӨЛ: Дотоод аудит

АУДИТЫН ХУГАЦАА: 2022 оны 1-9 дүгээр сар



## АГУУЛГА

Нэг. АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Хоёр. ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО

Гурав. ХАМРАХ ХҮРЭЭ

- Нийтлэг зөрчил

Дөрөв. ДҮГНЭЛТ

Тав. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

### **Нэг. Аудит хийх үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг тус тус баримтлан дотоод аудит хийлээ.

### **Хоёр. Дотоод аудитын зорилго:**

Улсын төсөв, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай, захиран зарцуулах, төсвийн удирдлага, шийдвэр, үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төсвийн ерөнхийлөн захирагч Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийх, аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгөх, хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны удирдлагуудад танилцуулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад аудитын зорилго оршино.

### **Гурав. Хамрах хүрээ:**

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 88 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2022 оны 3 дугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийв.

- Улсын төсвийн байгууллага 4;
- Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 1;
- Төрийн өмчит үйлдвэрийн газар 54;
- Төрийн өмчит хувьцаат компани 25;
- Төсөл, арга хэмжээ 4, нийт 88 төрийн байгууллага, хуулийн этгээд байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам, Зам, тээврийн хөгжлийн сайдын “Хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай” 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/79 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажиллаж байна.

Харьяа байгууллагууд шилэн дансны тайланг хуулийн хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 98 хувийн биелэлттэй байна.

### **Нийтлэг зөрчил:**

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (8);
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (13);
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (3);
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (13);
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (13);

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (8);
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (3);
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (3);
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (10);
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (5);
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (15);
- Концессийн мэдээлэл (9);
- Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл (7);
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (15);
- Байгууллагын батлагдсан төсөв (1);
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (11);
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (2) зэргийг хугацаа хоцроож оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Хоцроосон мэдээллийн тоо	1	2	3	4	6	7	8	9	10	12	14	15	18	23	26	Мэдээлээгүй	Бүрэн оруулсан
Байгууллагын тоо	18	8	5	1	3	1	1	1	1	3	1	1	1	1	1	1	40

Тайлант оны эхний хагас жилд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/130 дугаар тушаал гарч хугацаатай үүрэг чиглэл өгсөн.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн № 875/АО110001, АХГ-2022/05/НА-СТА-ТЕЗ албан шаардлагын дагуу Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, албан шаардлагын биелэлтийг ирүүлэхээр ХШҮДАГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 10/2695 дугаар албан бичгийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлсэн.

Албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ИНЕГ, ТӨХК, “АТҮТ” ТӨҮГ-ын Цогтцэций салбар, “Хөвсгөл АЗЗА”, “Завхан АЗЗА” ТӨХК, “Хар хорин АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК зэрэг байгууллагын шилэн данс хариуцсан холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж хариу ирүүлсэн.

#### **Тав. Дүгнэлт**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний 88 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийхэд 40 байгууллага Шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ хуулийн хугацаанд бүрэн байршуулсан, 18

байгууллага 1, 19 байгууллага 2-8, 10 байгууллага 9-26 мэдээллийг тус тус хугацаа хоцроож оруулсан байна. Энэ нь салбарын дундаж үнэлгээ буурахад нөлөөлж байна. Цаашид Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж ажиллав.

**Зургаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байх;

-“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

-Байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийн цахим хуудасны архивт хадгалан, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байх.

---o0o---